



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2018 оны 02 дугаар сарын 12

№ 01/10 АУА - 2018/4/СТА-ОНТС Мандалговь хот

Г

Төлбөр барагдуулах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Сум хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланд аудит хийх явцад Баянжаргалан сумын нэр бүхий 9 төсөл хэрэгжүүлэгчид гэрээнд заасны дагуу үндсэн зээл, зээлийн хүүг төлөлгүй хугацаа хэтрүүлснээс Сум хөгжүүлэх санд нийт 42,723,941.00 /Дочин хоёр сая долоон зуун хорин гурван мянга есөн зуун дөчин нэг/ төгрөгийн хохирол учруулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Иргэний тухай хуулийн 222.4-т /Хугацаа хэтрүүлсэн үүрэг гүйцэтгэгч нь түүнд ямар нэг тохиолдол нөлөөлсөн эсэхийг харгалзахгүйгээр хохирлыг хариуцна.../, 222.5-д /Мөнгөн төлбөрийн үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй бол үүрэг гүйцэтгэгч хэтрүүлсэн хугацаанд тохирсон хүү төлөх үүрэгтэй/, “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 4.7-д /Иргэн хуулийн этгээд авсан зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд сангийн дансанд буцаан төлнө, зээлдэгчтэй байгуулсан “Сум хөгжүүлэх сангаас зээл олгох гэрээ”-ний 3.2-т /Зээлдэгч авсан зээлийн төлбөр болон хүүг энэхүү гэрээний 1.3-т заасан хугацаанд бүрэн эргүүлэн төлөх үүрэг хүлээх буюу хавсралтанд тодорхойлсон төлбөрийн хуваарийн дагуу гүйцэтгэнэ/, заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д /Улсын болон орон нутгийн төсөв, Засгийн газрын тусгай сан, хөтөлбөр, биеэ даасан эрхийн актаар зохицуулагддаг сан, хөтөлбөр, батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан орлогыг дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй/, 3.1.7-т /Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан/ заалтуудыг тус тус үндэслэн

ТОГТООХ нь:

1. Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийг эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөөгүй, хугацаа хэтрүүлсэн нийт 42,723,941.00 */Дочин хоёр сая долоон зуун хорин гурван мянга есөн зуун дөчин нэг/* төгрөгийн зээлийн авлагыг нэр бүхий 40 зээлдэгч нараар нөхөн төлүүлэх;;
2. Төлбөрийн актыг Баянжаргалан сумын Сум хөгжүүлэх сангийн **100080555406** тоот дансанд 2018 оны 06 дугаар сарын 20-ны дотор төвлөрүүлэх.

Актыг тогтоосон хугацаанд бүрэн барагдуулах арга хэмжээ авах, биелэлтийг 2018 оны 06 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянжаргалан сумын Засаг дарга Г.Туяа, нягтлан бодогч Ц.Наранжаргал, жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн Э.Сувд нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН¹:

АХЛАХ
АУДИТОР



Ч.БЭРХСАЙХАН

ЗӨВШӨӨРСӨН:

ЗАСАГ
ДАРГА Г.ТУЯА
НЯГТЛАН
БОДОГЧ Ц.НАРАНЖАРГАЛ
ЖИЖИГ ДУНД
ҮЙЛДВЭРЛЭЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Э.СУВД

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.